

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэдэх
Ёс зүйн дэд хорооны 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн
сэтгүүл тоот албан бичгийн хавсралт



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.01.31

Нэг. Тус хүрээлэнгийн зүгээс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан шийдвэрийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1.1. Тус хүрээлэнгийн нийт 40 албан хаагчаас 34 албан хаагчийг хамруулан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг танилцуулсан.

1.2. Мөн 2024 оны 01 дүгээр сараас 12 дүгээр сарын хооронд Удирдлагын академийн “Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүй” сэдэвт цахим сургалтад нийт 31 албан хаагч хамрагдаж, гэрчилгээ авсан.

1.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг хэрэгжүүлэх үүднээс 2024 оны 06 дугаар сарын 20, 27-ны өдрүүдэд нийт албан хаагчийг хамруулан нууц санал хураалтаар байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгож, улмаар тус хүрээлэнгийн захирлын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/34 тоот тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг баталсан.

1.4. Төсвийн шууд захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/136 тоот тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд урамшуулал олгосон.

Хоёр. Тус хүрээлэнгийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

2.1. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр анхны хурлаа хийж, Ёс зүйн дэд хорооны дарга болон Нарийн бичгийн даргыг сонгож, мөн 2024 оны 8 дугаар сарын 03-ны өдөр хуралдаж, 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг баталсан.

2.2. Ёс зүйн дэд хорооноос 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 02/299 тоот албан бичгээр Ёс зүйн дэд хороо байгуулсан шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явцын мэдээллийг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.3. Мөн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/391 тоот албан бичгээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.4. Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөл, Улсын Их хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооноос хамтран 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга ба хэрэгцээ” сэдэвт

хэлэлцүүлэгт Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Ч.Халиун, Гишүүн С.Билигсайхан нар оролцсон.

2.5. Төлөвлөгөөний хүрээнд тус хүрээлэнгийн дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2021-2022 оны үйл ажиллагааны баримтуудыг архивлан архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.

2.6. Төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдаас харилцааны соёл, ур чадвар, ёс зүйн талаар тоон үзүүлэлт бүхий судалгаа авч, нэгтгэн, албан хаагч тус бүрт үнэлгээг танилцуулсан.

3. 2024 онд тус байгууллагын алба хаагчийн ёс зүйн асуудлаар иргэн, олон нийтээс гомдол, мэдээлэл ирүүлээгүй болно.